ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ӨВА-2022/146/НА-СТА-ТШЗ**


Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: О.Батжаргал
Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Гансүх
Утас: 70323833 Цахим хаяг: Gansukh.audit@gmail.com
Аудитор: Р.Цэрэндолгор
Утас: 70323108 Цахим хаяг: Tserendolgorr@audit.gov.mn


Цахим хуудас: www.audit.mn

Арвайхээр хот

2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /төгрөгөөр/ .... 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .... 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .... 4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .... 6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .... 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .... 8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .... 10
3. Аудитын тайлан .... 10
3.1 Ерөнхий зүйл .... 10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .... 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .... 11
3.4 Материаллаг байдал .... 11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .... 11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .... 12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .... 12
3.8 Аудитын гол асуудал .... 13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .... 13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .... 13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .... 13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .... 14
4. Аудитын илрүүлэлт .... 14
4.1 Залруулсан алдаа .... 14
4.2 Төлбөрийн акт .... 14
4.3 Албан шаардлага .... 14
4.4 Зөвлөмж .... 14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .... 14

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг.
Утас/Факс: (976) 7032 3253.
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022.02.15 № 181
танай ____________-ны №____________-т

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ТӨВИЙН ДАРГА Б.СҮХБААТАР ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /төгрөгөөр/

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| данс | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 10,927,946.00 | 21,529,466.00 |
| 33 | АВЛАГА | 462,844.00 | 6,433,266.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 462,844.00 | 109,000.00 |
| 335 | Бусад авлага | 00.00 | 6,324,266.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 00.00 | 6,324,266.00 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 00.00 | 1,611,380.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 00.00 | 1,611,380.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 10,465,102.00 | 13,484,820.00 |
| 351 | Түүхий эд материал | 1,391,530.00 | 1,370,530.00 |
| 35130 | Эм боох материал | 1,391,530.00 | 1,370,530.00 |
| 354 | Хангамжийн материал | 9,073,572.00 | 12,114,290.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,073,572.00 | 12,114,290.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 121,088,289.98 | 83,772,440.06 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 121,088,289.98 | 83,772,440.06 |
| 391 | Газар | 00.00 | 00.00 |
| 392 | Биет хөрөнгө | 88,408,289.98 | 83,772,440.06 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 12,808,433.94 | 971,250.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -11,259,927.46 | -194,250.00 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 87,075,074.60 | 87,075,074.60 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -44,044,144.28 | -57,571,431.08 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 115,508,871.21 | 131,866,278.38 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -73,521,336.52 | -82,160,420.29 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 9,247,362.86 | 11,687,362.86 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -7,406,044.37 | -7,901,424.41 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 00.00 | 00.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 32,680,000.00 | 00.00 |
| 39301 | Програм хангамж | 385,000.00 | 385,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -385,000.00 | -385,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 32,680,000.00 | 00.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 132,016,235.98 | 105,301,906.06 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 00.00 | 00.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 132,016,235.98 | 105,301,906.06 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 132,016,235.98 | 105,301,906.06 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 76,068,412.83 | 76,068,412.83 |
| 51101 | Өмч: - төрийн | 76,068,412.83 | 76,068,412.83 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 30,396,601.12 | 24,543,112.01 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 30,396,601.12 | 51,257,441.93 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -26,714,329.92 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 25,551,222.03 | 4,690,381.22 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 132,016,235.98 | 105,301,906.06 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| ДАНС | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 353,163,450.00 | 398,644,357.17 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 40,857,000.00 | 30,085,857.17 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 39,949,000.00 | 30,085,857.17 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 39,949,000.00 | 30,085,857.17 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 39,949,000.00 | 30,085,857.17 |
| 122 | Тусламжийн орлого | 908,000.00 | 00.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 908,000.00 | 00.00 |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | 00.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 312,306,450.00 | 368,558,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 283,476,700.00 | 316,624,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 283,476,700.00 | 316,624,900.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 28,829,750.00 | 51,933,600.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 3,654,150.00 | 10,985,700.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 25,175,600.00 | 7,580,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 33,367,900.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 334,708,168.04 | 392,137,481.79 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 334,708,168.04 | 392,137,481.79 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 333,408,379.04 | 369,836,541.79 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 197,943,394.46 | 215,560,853.00 |
| 210101 | Үндсэн цалин | 119,457,750.00 | 124,897,678.00 |
| 210102 | Нэмэгдэл | 51,411,500.00 | 63,767,895.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,893,500.00 | 8,194,000.00 |
| 210104 | Урамшуулал | 17,791,200.00 | 18,701,280.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 389,444.46 | 00.00 |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | 00.00 | 00.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 28,271,955.54 | 33,252,885.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,811,000.00 | 21,305,638.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,211,578.00 | 2,059,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,304,622.00 | 3,706,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 394,000.00 | 411,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,550,755.54 | 5,769,747.00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 00.00 | 00.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 27,084,560.00 | 18,401,740.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,346,200.00 | 964,660.00 |
| 210302 | Түлш, халаалт | 14,678,000.00 | 4,841,760.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 697,860.00 | 595,320.00 |
| 210304 | Байрны түрээс | 10,362,500.00 | 12,000,000.00 |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | 00.00 | 00.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 20,291,971.00 | 27,321,942.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 910,950.00 | 1,272,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,161,800.00 | 11,411,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 608,395.00 | 897,060.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 800,000.00 | 1,220,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,810,826.00 | 12,520,182.00 |
| 2105 | Нормативт зардал | 22,001,145.00 | 37,905,070.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 22,001,145.00 | 37,730,070.00 |
| 210502 | Хоол, хүнс | 00.00 | 00.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 175,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,918,500.00 | 4,532,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,918,500.00 | 4,532,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,950,500.00 | 8,593,100.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 00.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,950,500.00 | 8,593,100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,164,301.00 | 1,376,400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 188,930.00 | 378,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 130,000.00 | 200,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 165,160.00 | 314,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 84,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 214,781.00 | 199,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 182,430.00 | 200,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,782,052.04 | 22,892,051.79 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 943,340.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 00.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 25,838,712.04 | 22,892,051.79 |
| 210904 | Найдваргүй авлагын алдагдал | 00.00 | 00.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,299,789.00 | 22,300,940.00 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 90,115.00 | 00.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 90,115.00 | 00.00 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 00.00 | 00.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,209,674.00 | 22,300,940.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,209,674.00 | 22,300,940.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 18,455,281.96 | 6,506,875.38 |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 00.00 | 00.00 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 00.00 | 33,221,205.30 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 33,221,205.30 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | 00.00 | -33,221,205.30 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 18,455,281.96 | -26,714,329.92 |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 43,388,412.83 | 17,673,708.48 | 12,541,387.54 | 73,603,508.85 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 43,388,412.83 | 17,673,708.48 | 12,541,387.54 | 73,603,508.85 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 65,858,702.27 | 00.00 | -21,159,311.92 | 44,699,390.35 |
| C08 | 2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 76,068,412.83 | 25,551,222.03 | 30,396,601.12 | 132,016,235.98 |
| D01 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 76,068,412.83 | 25,551,222.03 | 30,396,601.12 | 132,016,235.98 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 20,860,840.81 | 20,860,840.81 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 76,068,412.83 | 25,551,222.03 | 51,257,441.93 | 152,877,076.79 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -20,860,840.81 | 00.00 | -20,860,840.81 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -8,809,078.17 | -8,809,078.17 |
| D09 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 76,068,412.83 | 4,690,381.22 | 42,448,363.76 | 123,207,157.81 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| ДАНС | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 312,306,450.00 | 368,558,500.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 312,306,450.00 | 368,558,500.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 283,476,700.00 | 316,624,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 283,476,700.00 | 316,624,900.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 28,829,750.00 | 51,933,600.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 3,654,150.00 | 10,985,700.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 25,175,600.00 | 7,580,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 33,367,900.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 308,003,050.00 | 360,921,500.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 308,003,050.00 | 360,921,500.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 306,703,261.00 | 338,620,560.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 197,712,800.00 | 217,941,662.00 |
| 210101 | Үндсэн цалин | 118,608,300.00 | 128,024,366.00 |
| 210102 | Нэмэгдэл | 51,611,300.00 | 63,022,016.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 9,702,000.00 | 8,194,000.00 |
| 210104 | Урамшуулал | 17,791,200.00 | 18,701,280.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 28,661,400.00 | 31,601,438.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,811,000.00 | 21,305,638.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,970,100.00 | 2,059,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,546,100.00 | 3,706,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 394,000.00 | 411,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,940,200.00 | 4,118,300.00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 00.00 | 00.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 27,084,560.00 | 23,533,800.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,346,200.00 | 1,146,300.00 |
| 210302 | Түлш, халаалт | 14,678,000.00 | 9,678,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 697,860.00 | 709,500.00 |
| 210304 | Байрны түрээс | 10,362,500.00 | 12,000,000.00 |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | 00.00 | 00.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 17,471,300.00 | 20,647,160.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 955,950.00 | 1,245,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,161,800.00 | 11,411,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 608,395.00 | 897,060.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 800,000.00 | 1,220,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,945,155.00 | 5,872,900.00 |
| 2105 | Нормативт зардал | 23,470,600.00 | 22,000,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 20,970,600.00 | 19,500,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,500,000.00 | 2,500,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,987,500.00 | 12,818,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 2,243,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 6,025,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,987,500.00 | 4,550,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,950,500.00 | 8,702,100.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 00.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,950,500.00 | 8,702,100.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 00.00 | 00.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,164,601.00 | 1,376,400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 188,930.00 | 378,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | 00.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 130,000.00 | 200,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 165,160.00 | 314,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 84,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 214,781.00 | 199,600.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 182,730.00 | 200,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,200,000.00 | 00.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,200,000.00 | 00.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,299,789.00 | 22,300,940.00 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 90,115.00 | 00.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 90,115.00 | 00.00 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 00.00 | 00.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,209,674.00 | 22,300,940.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,209,674.00 | 22,300,940.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 4,303,400.00 | 7,637,000.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 4,303,700.00 | 7,637,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 4,303,700.00 | 7,637,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 4,303,700.00 | 7,637,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 4,303,700.00 | 7,637,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -4,303,700.00 | -7,637,000.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | -300.00 | 00.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 300.00 | 00.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 283,476,700.00 | 283,386,885.00 | 316,624,900.00 | 316,624,900.00 | 100.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 283,476,700.00 | 283,386,885.00 | 316,624,900.00 | 316,624,900.00 | 100.00 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 283,062,700.00 | 282,972,885.00 | 316,064,900.00 | 316,064,900.00 | 100.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 197,712,800.00 | 197,712,800.00 | 205,917,300.00 | 205,917,300.00 | 100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 118,608,300.00 | 118,608,300.00 | 126,355,500.00 | 128,024,366.00 | 101.32 |
| 210102 | Нэмэгдэл | 51,611,300.00 | 51,611,300.00 | 50,906,500.00 | 50,997,654.00 | 100.18 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | 9,702,000.00 | 9,702,000.00 | 9,702,000.00 | 8,194,000.00 | 84.46 |
| 210104 | Урамшуулал | 17,791,200.00 | 17,791,200.00 | 18,953,300.00 | 18,701,280.00 | 98.67 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 28,661,400.00 | 28,661,400.00 | 29,857,900.00 | 29,857,900.00 | 100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,811,000.00 | 18,811,000.00 | 19,562,100.00 | 19,562,100.00 | 100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,970,100.00 | 1,970,100.00 | 2,059,200.00 | 2,059,200.00 | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 3,546,100.00 | 3,546,100.00 | 3,706,500.00 | 3,706,500.00 | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 394,000.00 | 394,000.00 | 411,800.00 | 411,800.00 | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,940,200.00 | 3,940,200.00 | 4,118,300.00 | 4,118,300.00 | 100.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 16,399,300.00 | 16,399,300.00 | 23,533,800.00 | 23,533,800.00 | 100.00 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 1,346,300.00 | 1,346,200.00 | 1,146,300.00 | 1,146,300.00 | 100.00 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 14,677,900.00 | 14,678,000.00 | 9,678,000.00 | 9,678,000.00 | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 375,100.00 | 375,100.00 | 709,500.00 | 709,500.00 | 100.00 |
| 210304 | Байрны түрээс | | | 12,000,000.00 | 12,000,000.00 | 100.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 15,573,000.00 | 15,572,995.00 | 16,569,400.00 | 16,569,400.00 | 100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 604,800.00 | 604,800.00 | 604,800.00 | 640,800.00 | 105.95 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 11,411,800.00 | 11,411,800.00 | 11,411,800.00 | 11,411,800.00 | 100.00 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 608,400.00 | 608,395.00 | 608,400.00 | 608,400.00 | 100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 800,000.00 | 800,000.00 | 1,256,400.00 | 1,220,400.00 | 97.13 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 2,148,000.00 | 2,148,000.00 | 2,688,000.00 | 2,688,000.00 | 100.00 |
| 2105 | Нормативт зардал | 13,315,000.00 | 13,315,000.00 | 22,000,000.00 | 22,000,000.00 | 100.00 |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл | 10,815,000.00 | 10,815,000.00 | 19,500,000.00 | 19,500,000.00 | 100.00 |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 2,500,000.00 | 2,500,000.00 | 2,500,000.00 | 2,500,000.00 | 100.00 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 3,600,000.00 | 3,600,000.00 | 9,625,000.00 | 9,625,000.00 | 100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,500,000.00 | 1,500,000.00 | 1,500,000.00 | 1,500,000.00 | 100.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | | | 6,025,000.00 | 6,025,000.00 | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,100,000.00 | 2,100,000.00 | 2,100,000.00 | 2,100,000.00 | 100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,950,500.00 | 6,950,500.00 | 7,750,500.00 | 7,750,500.00 | 100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,950,500.00 | 6,950,500.00 | 7,750,500.00 | 7,750,500.00 | 100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 850,700.00 | 760,890.00 | 811,000.00 | 811,000.00 | 100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 250,000.00 | 250,000.00 | 200,000.00 | 200,000.00 | 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 173,000.00 | 130,000.00 | 314,000.00 | 314,000.00 | 100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 165,200.00 | 165,160.00 | 84,000.00 | 84,000.00 | 100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 80,000.00 | 33,000.00 | 13,000.00 | 13,000.00 | 100.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 182,500.00 | 182,730.00 | 200,000.00 | 200,000.00 | 100.00 |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 414000.00 | 414000.00 | 560,000.00 | 560,000.00 | 100.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 414,000.00 | 414,000.00 | 560,000.00 | 560,000.00 | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 414,000.00 | 414,000.00 | 560,000.00 | 560,000.00 | 100.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 283,476,700.00 | 283,476,700.00 | 316,624,900.00 | 316,624,900.00 | 100.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 283,476,700.00 | 283,476,700.00 | 316,624,900.00 | 316,624,900.00 | 100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 283,476,700.00 | 283,476,700.00 | 316,624,900.00 | 316,624,900.00 | 100.00 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 14.00 | 14.00 | 14.00 | 14.00 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 1.00 | 1.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 10.00 | 10.00 | 10.00 | 10.00 | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 03.00 | 03.00 | 3.00 | 3.00 | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 52,012,340.00 | 51,933,600.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 52,012,340.00 | 51,933,600.00 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 30,271,400.00 | 30,192,660.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 12,024,362.00 | 12,024,362.00 |
| 210102 | Нэмэгдэл | 12,024,362.00 | 12,024,362.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,743,538.00 | 1,743,538.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,743,538.00 | 1,743,538.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 4,156,500.00 | 4,077,760.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 604,200.00 | 604,200.00 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 367,400.00 | 288,660.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 3,184,900.00 | 3,184,900.00 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 10,830,000.00 | 10,830,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8,380,000.00 | 8,380,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,450,000.00 | 2,450,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 951,600.00 | 951,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 951,600.00 | 951,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 565,400.00 | 565,400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 378,800.00 | 378,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 186,600.00 | 186,600.00 |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 21,740,940.00 | 21,740,940.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 21,740,940.00 | 21,740,940.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 21,740,940.00 | 21,740,940.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 51,933,600.00 | 51,933,600.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 51,933,600.00 | 51,933,600.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 10,985,700.00 | 10,985,700.00 |
| 131103 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,580,000.00 | 7,580,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 33,367,900.00 | 33,367,900.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Р.Цэрэндолгор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Зоонозын өвчин судлалын төв нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.02.01-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Зоонозын өвчин судлалын төв нь "Хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг оновчтой зохион байгуулах, зоонозын өвчний тархалтын тандалт судалгааг хийх, хүн амыг уг халдварт өртөх эрсдэлээс сэргийлэх" чиг үүрэгтэй байгууллага юм

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт зардлын үзүүлэлтээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 398.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 3.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө болон бараа материалын тодруулгыг бэлтгэжээ:

- Үндсэн хөрөнгө өмнөх оноос 25.7 сая төгрөгөөр буурсан нь аймгийн БОЭТ-д балансаас балансад шилжүүлсэн 32.7 сая төгрөгийн газар, 11.8 сая төгрөгийн конторын барилга акталж хассантай холбоотой байна.

- Бараа материал өмнөх оноос 3.1 сая төгрөгөөр өссөн нь худалдан авсан аж ахуйн материал нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төслийг хуулийн хугацаанд бэлтгэж, ЭМГ-т нэгтгүүлж ирсэн байна. 2021 оны төсвийн төсөлд нийт зардлыг 316.6 сая төгрөгөөр төлөвлөсөн ба санхүүжилт 316.6 сая төгрөгөөр батлагджээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 316.6 сая төгрөгөөр санхүүжигдэн, 316.6 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөцөөс 7.5 сая төгрөгийг, Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн орлого 10.9 сая төгрөг, Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгийн орлого 33.6 сая төгрөг нийт 52 сая төгрөгийг санхүүжүүлэн бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 0.5 сая төгрөгийг, томилолт, зочны зардалд 0.9 сая төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 10.8 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 4.1 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 1.7 сая төгрөг, цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд 12.0 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 21.7 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

### 3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 2 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Зоонозын өвчин судлалын төв нь шилэн дансны цахим хуудсанд нийт 149 мэдээлэл байршуулахаас 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол зэрэг бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шалгасан зүйлсийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэсэн болно.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд ямар нэгэн зөрчил илрээгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

### 4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй

### 4.2 Төлбөрийн акт

Байхгүй болно.

### 4.3 Албан шаардлага

Байхгүй болно.

### 4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Зоонозын өвчин судлалын төвийн | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 00 |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР Р.ЦЭРЭНДОЛГОР

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 11-НЫ ӨДӨР